
МЭДЭЭ · 2024 оны 12-р сарын 9

ТӨРИЙН ЦЭРГИЙН БОЛОН ХУУЛЬ САХИУЛАХ БАЙГУУЛЛАГУУДЫН "КЛАССИК ПАУЭРЛИФТИНГИЙН ТЭМЦЭЭН"-Д АМЖИЛТТАЙ ОРОЛЦЛОО



Монгол улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын Классик пауэрлифтингийн аварга шалгаруулах 2 дах удаагийн тэмцээн 2024 оны 12 дугаар сарын 06-07-ны өдрүүдэд Улаанбаатар хотод зохион байгуулагдлаа.

Энэ жилийн тэмцээнд Прокурорын байгууллагыг төлөөлөн Нийслэлийн Баянзүрх дүүргийн прокурорын газрын ахлах прокурор А.Цэрэнсодном оролцож, -74 кг-ын жинд Классик пауэрлифтингийн суултын төрөлд мөнгө, шахалтын төрөлд алт, таталтын төрөлд алт, нийлбэр дүнгээр 3 алт, 1 мөнгөн медаль хүртэж тус тэмцээний хошой аварга болсон байна.

Тэмцээнд Төрийн цэргийн болон Хууль сахиулах тусгайлсан чиг үүрэг бүхий 16 байгууллагын 250 гаруй тамирчид оролцсон байна.



Эх сурвалж: https://prosecutor.mn/post/1024